



Байгаль орчинд нөлөөлөх
байдлын үнэлгээнд олон
нийтийн оролцоог хангах эрх
зүйн зохицуулалтыг
боловсронгуй болгох нь

Бодлогын судалгааны тайлан

Энэхүү судалгааны тайланг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас тавьсан хүсэлтийн дагуу Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕП2) хүрээнд боловсруулсан бөгөөд АМЕП 2 хөтөлбөрийг Австрали Улсын Гадаад харилцаа худалдааны яам санхүүжүүлэн, Адам смит Интернэйшнл компани хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь: Бодлогын судалгааны тайлан

Энэ судалгааны тайланг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох төслийн хүрээнд боловсруулав. Ингэхдээ төслийн хүрээнд хийсэн БОНБУ-ний хууль, журмын дүн шинжилгээ, ИНХ-ын хэлэлцүүлгийн тэмдэглэл, тогтоолын дүн шинжилгээ, статистик өгөгдлийн шинжилгээ, оролцогч талуудын ярилцлага судалгаа, олон улсын туршлагын судалгааны үр дүнд тулгуурласан болно.

Бодлогын судалгааны тайланг боловсруулсан: АМЕП-2 төслийн олон нийтийн оролцооны зөвлөх Доктор Д.Бямбажав

2021 оны 6 сарын 15

Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт	4
БОНБУ-ний тогтолцоо	5
Олон нийтийн оролцооны зохицуулалт	6
Хуулийн хэрэгжилт	7
Тулгамдаж буй асуудлууд.....	11
Шийдлийн хувилбарууд	14
Олон улсын туршлага	17
Бодлогын зөвлөмжүүд.....	19
Хавсралт	22

Товчилсон үгийн жагсаалт

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОГ	Байгаль орчны газар
БОЯ	Байгаль орчны яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОННУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
ЗЗНДНтХ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль
ЕҮД	Ерөнхий үнэлгээний дүгнэлт
ОХУ	Оросын Холбооны Улс
СНҮ	Стратегийн нөлөөллийн үнэлгээ
ТБҮ	Төлөв байдлын үнэлгээ

БОНБУ-ний тогтолцоо

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулдаг.


Стратегийн нөлөөллийн үнэлгээ (CHY) нь хөтөлбөр, төлөвлөгөөнд хамаардаг бол төслийн үнэлгээнд Ерөнхий Үнэлгээ (EY), Нарийвчилсан үнэлгээ (БОННУ) хамаарна.

Үнэлгээний тоо (1995-2021)



Харин Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (ТБҮ) нь төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлох зорилгоор хийдэг тойм судалгаа юм. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ (ХНҮ) нь хэд хэдэн төслүүдээс үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоох зорилгоор хийдэг. БОННУ-ний хувьд мэргэжлийн шинжээч, Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн БОАЖЯ шийдвэр гаргадаг.

2010-2020 онд нийт 3003 буюу дунджаар сард 30, жилд 300 орчим БОННУ батлагдсан байна.



БОННУ-г төсөл хэрэгжүүлэгчийн захиалгаар үнэлгээ хийх эрх бүхий дотоодын аж ахуйн нэгж хэрэгжүүлдэг. Өнөөдрийн байдлаар БОННУ хийх эрх авсан 95 аж ахуйн нэгж бүгд Улаанбаатар хотод төвлөрч байна.

Олон нийтийн оролцооны зохицуулалт

2012 онд УИХ-аас БОНБУ-ний хуулийг шинэчлэн батлахдаа 5 заалт бүхий “Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо” гэдэг тусгай зүйлийг оруулсан. Уг хуульд нийцүүлэн 2014 онд БОАЖЯ “БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах журам”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар”-ыг баталсан байна. Хууль, журмын дараах заалтууд нь БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах гол зохицуулалт болж байна. Үүнд:

БОНБУ-ний хууль

 · “Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна” /18.4/

 · Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах асуудлын жагсаалтад “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл”-ийг /8.4.8/ оруулсан.

 · “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээ хийгдэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ” /18.1/

 · “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна” /10.5/


“БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах журам”

Үе шат	Журмын заалтууд
БОННУ хийхээс өмнө	2.4.1.орон нутгийн захиргааны байгууллага нь тухайн орон нутагт хэрэгжих төслийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах; 2.4.2.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний шийдвэр, тухайн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн саналыг байгаль орчны мэдээллийн санд оруулах.
БОННУ хийх явцад	2.5.3.нөлөөллийг таамаглах үе шатанд иргэдтэй уулзалт хийх, оролцооны аргаар үнэлэх аргачлалыг ашиглан иргэдийн саналыг бүрэн авах; 2.5.4.нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах. 2.6.Төсөл хэрэгжүүлэгч төслийн талаарх ойлголт, эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдэд дэлгэрэнгүй танилцуулж, иргэд, олон нийтийн оролцоог хангахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлж өгч болно.
БОННУ-ний тайланг боловсруулж дууссаны дараа	2.7.Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна. 2.8.Хэрэв тухайн төсөл нь хэд хэдэн баг, сумын нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих бол тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хуралд тус тусад нь танилцуулж санал авна.

	2.10.Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон саналаа тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хуралд төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө хүргүүлсэн байна.
БОННУ батлагдсаны дараа	1.5.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээ хийгдсэн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх, аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна. Менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгана. 2.11.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна. 2.12.Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангаж, хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, олон нийтэд танилцуулж байна.
Гомдол маргаан шийдвэрлэх	4.5.Үнэлгээний тайлангийн талаарх гомдол, маргааныг иргэд, олон нийтийн зүгээс төсөл хэрэгжүүлэгч, тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж, орон нутгийн удирдах байгууллагад эхлэн гаргана. 3.7.Шат дараалан тавьсан гомдол, маргааны шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах бөгөөд хянан шийдвэрлэсэн дүгнэлтийг иргэд, олон нийт хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

Хуулийн хэрэгжилт


Энэ төслийн хүрээнд хууль, журмын хэрэгжилтийн талаар үнэлгээ эрхлэгч, төсөл хэрэгжүүлэгч, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийг төлөөлсөн 115 оролцогчдыг хамарсан судалгааг 2021 оны 4-5 сард Хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран хийсэн.¹



Үнэлгээ эрхлэгчид хуульд заасан ИНХ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэлийг үнэлгээний тайланд хавсаргах шаардлага зохих хэмжээнд хэрэгждэг гэж үзсэн байна. Яамны зүгээс

¹ АМЭП2. БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах нь: Оролцогч талуудын судалгаа. 2021

үнэлгээний тайлангийн бичиг баримтын бүрдүүлэлтийг шалгахдаа энэ тогтоол, тэмдэглэлийг хатуу шаарддаг байна.



Харин процесс буюу иргэдийн саналыг авах, хэлэлцүүлэг зохион байгуулах үйл явц үр дүнтэй явагдаж, байгаль орчны шийдвэр гаргахад ач холбогдолтой мэдээллийг танилцуулах, оршин суугч, нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах талаасаа хангалтгүй байна гэж зарим үнэлгээ эрхлэгчид үзсэн байна. Олон нийтийн оролцоог хангах журмын хэрэгжилт жигд биш, ялангуяа жижиг, дунд хэмжээтэй төслүүдийн хувьд хангалтгүй байна гэж үзсэн байна.

БОННУ хийх явцад иргэдээс санал авах зохицуулалт

Үнэлгээ эрхлэгч нь төслийн төлөв байдлын үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээг үргэлжлүүлэн буюу хамтад нь хийхээр төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээлж хийх нь нийтлэг практик байна. Иймээс төслийн төлөв байдлын үнэлгээнд оруулдаг төслийн талбай, нөлөөллийн бүсийн өрхүүдийн судалгааг олон нийтийн саналыг авч буй нэг арга гэж үздэг байна.

Үнэлгээний компаниуд иргэдээс мэдээлэл цуглуулах, санал авах ажлыг журмын дагуу, хангалттай сайн хийхгүй, мэдээлэл хүргэх, оролцооны асуудлыг орон нутгийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгчийн хариуцлага гэж үзэх байдал их байна. Үүнд иргэдээс санал авч буй аргачлал нь тодорхой бус, тайланд хэрхэн тусгасан талаар мэдэх боломжгүй байдаг, хотод байдаг учраас орон нутгийн талаар хангалттай сайн судлах, иргэдтэй уулзах боломж багатай, орон нутгийн онцлогийн талаар мэдээлэл муу байдгаас асуудлын гүн рүү оролгүй өнгөц дүгнэлт хийдэг гэж бусад оролцогч талууд үзсэн байна.


БОННУ-ний тайланг ИНХ-аар хэлэлцүүлэх зорилгын талаарх ойлголтын зөрүү

Судалгаанд оролцсон 30 үнэлгээ эрхлэгчдийн 29 нь багийн Иргэдийн Нийтийн Хурал /ИНХ/-аар үнэлгээг танилцуулж санал авдаг гэж хариулсан. Харин Улаанбаатар хотод хорооны ИНХ-ын тэргүүлэгчдийн хурал эсвэл Засаг даргын зохион байгуулсан хуралд танилцуулж санал авах байдал нийтлэг байна.



Түүнчлэн зарим оролцогчид хорооны хурлаар хэлэлцүүлж санал авсан гэдэг хуурамч бичиг гаргуулах явдал их байдаг тухай дурдсан байна.

Оролцогч талуудын дунд, ялангуяа орон нутгийн удирдлага, иргэдийн дунд БОННУ-ний тайланг ИНХ-аар хэлэлцүүлэх үйл ажиллагааг төслийг дэмжих эсэх тухай санал гэсэн ойлголт их байна. Түүнчлэн БОАЖЯ-наас ИНХ-ын тогтоолыг шалгаж үзэхдээ дэмжих санал өгсөн эсэхэд анхаарах хандлагатай байдгийг оролцогч талууд дурдсан байна. Ерөнхий үнэлгээний дүгнэлтүүдийг шинжлэн үзэхэд яамнаас “ИНХ-ын санал, шийдвэр, тэмдэглэл” гэж тодорхой шийдвэр шаардах нь нийтлэг байна. Ийм хандлага нь зарим ноцтой үр дагавартай байна. Үүнд:



- Хурлаар дэмжихгүй бол энэ төсөл цаашаа үргэлжлэх боломжгүй юм байна гэсэн ойлголтоор өөрт ашигтай байдал үүсгэхийг оролдох
- Дэмжих, дэмжихгүй гэдэг олонхын байр суурьт холбогдуулж иргэдийг буруушаах хандлага байдаг тул тодорхой санал хэлэхээс зайлсхийх
- Нөлөөлөлд өртөж болзошгүй эсвэл өртөж буй иргэдийн оролцоо, саналын үнэ цэнэ үгүй болж орон нутгийн удирдлага, тодорхой хэсэг хүмүүсийн байр суурь давамгайлах
- Саналаа худалдах буюу дэмжих санал өгсний хариуд амин хувийн дэмжлэг авах сэдэл үүсгэх

ИНХ-ын хэлэлцүүлгийн зохион байгуулалт

Журамд төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч хамтран БОННУ-ний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлж санал авахаар заасан нь ч амьдралд нийцэлгүй байна. Судалгаанд оролцогчдын мэдээлснээр баг, хороодын хурлын тогтсон хуваарь буюу тов байдаггүй бөгөөд жилд дунджаар 2-4 удаа болдог ИНХ-ын хуралдааны товыг хүлээж, хэрэв хуралдааны тов эрт буюу ойрхон зарлагдсан бол 1-3 сард багтаан хэлэлцүүлэгт орох, хэрэв тухайн улиралд амжаагүй эсвэл хуралдаан товлогдохгүй удах тохиолдолд 1-3 сар хүлээх болдог байна. 10 тайлан буюу нийт 22 тайлангийн 45 хувь нь Ерөнхий үнэлгээний дүгнэлт /ЕҮД/ батлагдсанаас хойш 1 сарын дотор ИНХ-аар хэлэлцүүлсэн байна. 5 тайланг 2-3 сарын дотор, 4 тайланг 4 сар болон түүнээс дээш хугацаанд ИНХ-аар хэлэлцүүлсэн байна.

ИНХ-ын тов тогтсон хуваарьгүй, тодорхойгүй байдал нь дараах сөрөг үр дагаврыг учруулдаг байна. Үүнд:

- Тухайн төслийн төлөвлөлт, явцыг удаашруулах, зогсоох, улмаар эдийн засгийн үнэ цэнэ буурдаг.
- 3-6 сараар хүчинтэй байхаар гардаг Ерөнхий үнэлгээний хугацаа дуусдаг тул дахин дүгнэлт гаргуулах болж чирэгдэл үүсдэг.
- Хурлын зохион байгуулахын тулд орон нутгийн удирдлагаас гуйх, тэдэнд нөлөөлөх, тохиролцох, авлигал өгөх зэрэг үйлдэл хийхэд хүргэдэг.
- Хуралдаан болсон мэт хуурамч бичиг баримт бүрдүүлэх зөрчил гардаг.

Улаанбаатар хотын хороодын хувьд ИНХ-ын давтамж харьцангуй олон боловч дээрх тодорхойгүй байдал болон сөрөг үр дагаврууд мөн адил гардаг байна.

Ирц бүрдээгүйн улмаас хурал хойшлох, хэлэлцүүлгийг хийх боломжгүй тарах асуудлууд үүсдэг байна. Ирц нь иргэдийн идэвх, зохион байгуулалт, суурьшлын тархалт, багийн удирдлагын хариуцлага, зохион байгуулалтын асуудал учраас орон нутаг бүрд харилцан адилгүй байна.

ИНХ-аар БОННУ-ний тайланг хэлэлцүүлэхэд иргэдэд зар мэдээ хүргэх, тайлангийн мэдээлэл, түүнийг уншиж ойлгоход шаардлагатай хугацаа олгох талаар зохицуулалт журамд байхгүй. Зөвхөн үнэлгээний тайланг хэлэлцэх ээлжит бус хурал зохион байгуулах тохиолдол маш цөөн учраас ихэнхдээ ИНХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах байдлаар үнэлгээний тайланг хэлэлцүүлж байна. Орон нутгийн “дотоод” асуудлаа хэлэлцэж дуусаад үнэлгээний тайлангийн танилцуулгыг сонсож хэлэлцдэг жишиг нийтлэг байна.

Байгаль орчны үнэлгээний ажилд холбогдолгүй асуулт, саналууд их гардаг шалтгааныг зарим үнэлгээ эрхлэгчид дараах шалтгаантай гэж үзсэн байна. Үүнд:

- Ашиг сонирхлын зөрчилтэй буюу төсөлд зөвшөөрөл өгөх гэж байна гэдэг хандлагаар асуулт, саналууд хэлдэг.
- Төслийн талаарх ойлголт дутмаг, мэдээлэл аваагүй байдаг учраас оновчтой асуулт, санал хэлэх боломжгүй байхын зэрэгцээ бусдын нөлөөлөлд амархан ороход хүргэдэг.

Үнэлгээний тайлангийн хураангуйг бэлтгэж орон нутгийн удирдлагад танилцуулах тохиолдол байдаг боловч орон нутгийн удирдлага, үнэлгээ эрхлэгчдээс иргэдэд хүргэх байдал бага, зарим компаниуд хурал болох өдөр танилцуулга материал бэлтгэж ирдэг байна. Тиймээс иргэд БОННУ-ний талаар мэдээлэлгүйгээр ИНХ-д оролцож, үнэлгээ эрхлэгчийн 20 орчим минутын товч танилцуулгыг сонсоод өөрсдийн байр суурийг илэрхийлэх шаардлага үүсдэг.

2014-2018 онд янз бүрийн чиглэлээр батлагдсан БОННУ-ний 22 тайлангийн баг, хорооны ИНХ-ын тогтоол, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг судлан үзэхэд ИНХ, ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол нь 100 хувь дэмжсэн агуулгатай боловч иргэдээс үнэлгээний тайлангийн тодорхой асуудлаар биш төслийн талаар ерөнхий ойлголт авахыг хүссэн, ерөнхий санал гаргасан байдал нийтлэг байна.

БОННУ-ний тайлангийн ил тод байдал

БОННУ-ний хуулиар үнэлгээ эрхлэгч нь БОННУ-ний батлагдсан тайланг БОАЖЯ, төсөл хэрэгжүүлэгч, төсөл хэрэгжих сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт тус бүр нэг хувийг өгөх үүрэгтэй. Харин журмаар уг тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна гэж заасан.

БОАЖЯ хуульд зааснаар БОННУ-нд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг БОННУ-ний мэдээллийн сангаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг. Үүнд төсөл, БОННУ-ний талаарх товч мэдээлэл, БОННУ-ний тайлангийн дараах хэсгүүдийг файлаар байршуулсан байна.

- Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ
- Эрсдлийн үнэлгээ, менежмент
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэлд дурдсан асуулт, саналын агуулга



- Олон нийтийн оролцоог хангуулсан талаарх баримт бичиг

Судалгаагаар орон нутгийн удирдлага үнэлгээний тайлангийн нэг хувийг хүлээн авдаг боловч иргэд уншиж танилцах боломж маш хязгаарлагдмал байна. Үүнд хэд хэдэн шалтгаан байгааг судалгаанд оролцогчид дурдсан байна. Үүнд:

- Үнэлгээний тайлан нь нийтэд ил тод баримт бичиг үү эсвэл нууцын зэрэглэлтэй баримт бичиг үү гэдэг ойлголт янз бүр байна.
- Үнэлгээний тайланг хаанаас үзэж танилцаж болох тухай нээлттэй мэдээлэл иргэдэд байхгүй байна.
- Орон нутгийн иргэд уншиж танилцах сонирхол бага, уншиж танилцсан ч ойлгоход бэрхшээлтэй нүсэр материал гэж үздэг учраас иргэдэд нээлттэй байлгах сонирхол бага байдаг.

Үнэлгээний тайлан батлагдахаас өмнө иргэд уншиж танилцах боломж маш байдаг гэдгийг үнэлгээ эрхлэгчид хүлээн зөвшөөрч байна. Нэгдүгээрт, хуулийн дагуу тайлан батлагдахаас өмнө орон нутагт тайланг хүргүүлэх, нээлттэй мэдээлэх хуулийн шаардлага байхгүй. Хоёрдугаарт, иргэдийн хувьд тайланг бүрэн эхээр нь унших сонирхол бага байдаг гэж үзсэн байна. Гуравдугаарт, төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээ эрхлэгчид үнэлгээний тайлангаа олон нийтэд дэлгэх сонирхол бага байдаг байна.

Тулгамдаж буй асуудлууд

Үүрэг хариуцлагын тодорхойгүй байдал

БОНБУ-ний тухай хууль, холбогдох журамд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг тусгахдаа хэн, хэзээ, хэрхэн гэдэг үүрэг, хариуцлагын тодорхой байдал, уялдааг хангаагүйн улмаас ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатны мэдээлэл өгөх, санал авах ажил орхигдох, улмаар ИНХ-аар хэлэлцүүлж, санал авах үйл ажиллагаа нь утга учиртай, мэдээлэлд суурилсан байж чадахгүй байна.

Журмын зохицуулалт

БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмын үндсэн хэсгийн зүйл, заалт бүрийг шинжлэн үзэхэд тэдгээрийн 90 орчим хувийг нэг мөр ойлгомжтой, холбогдох хууль, журам, аргачлалтай нийцүүлэн шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.


Журмын зарим бүрэлдэхүүн хэсгүүд, ялангуяа стратегийн нөлөөллийн үнэлгээний зохицуулалт нь тодорхой хугацаа, арга хэлбэрийг тусгасан ололттой талуудтай байгаа боловч журмыг бүхэлд нь шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Үнэлгээний тус бүр нь бие даасан бүлэгтэй, үнэлгээ эхлэхээс батлагдах хүртэлх үе шатанд оролцоог хангах шаардлага, зохицуулалтыг тодорхой тусгасан байхаар шинэчлэн боловсруулах нь үр дүнтэй юм. 2014 онд журам батлагдсанаас хойш холбогдох хуулиудад олон нийтийн оролцоог хангахтай холбоотой чухал өөрчлөлт орж, мөн шинээр хууль, журам цөөнгүй батлагдсан учраас тэдгээрт тусгагдсан зохицуулалттай уялдуулах, сайн жишгийг журамд тусгах нь зүйтэй юм. Ялангуяа олон нийтэд зар мэдээ хүргэх, мэдээлэл өгөх, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн саналыг боловсруулах, тайлагнах зохицуулалтуудыг журамд амьдралд нийцэлтэй байдлаар тусгах шаардлагатай байна.

БОННУ-нд хамрагдах төслийн ерөнхий шалгуур


БОННУ-нд хамрагдах төслийн хүрээ маш өргөн учраас БОАЖЯ-ны шинжээчид, Мэргэжлийн зөвлөлийн ачаалал их байдаг. Нөгөөтэйгүүр БОННУ хийлгэх том, жижиг бүхий л төслүүдэд олон нийтийн оролцоог хангах ижилхэн шаардлага тавьдаг маш их

хийдэл гардаг. Түүний улмаас жижиг, дунд төслүүдийн хувьд утга учиртай, үр дүнтэй оролцоог хангахаас илүүтэй орон нутгаас “бичгээ авах”-д анхаардаг хандлага их байна.

БОНБУ-ний мэдээллийн сангийн мэдээлэлд хийсэн бидний дүн шинжилгээнээс үзэхэд 2019 оны байдлаар ЕҮД-ийн 60 хувь нь нарийвчилсан үнэлгээг 4-6 сарын хугацаанд хийхээр заасан бол бодит байдал дээр 35 орчим хувь нь л 4-6 сарын хугацаанд нарийвчилсан үнэлгээ хийж дуусган батлуулж, үлдсэн 25 хувь нь 2-3 сарын хугацаанд дуусгаж батлуулсан байна. КОВИД-19 цар тахалтай холбоотой хязгаарлалтаас өмнө буюу 2019 онд нийт нарийвчилсан үнэлгээний 20 орчим хувь нь 1 сарын хугацаанд батлагдаж, 10 орчим хувь нь 10-аас дээш сарын хугацаанд батлагдсан ялгаатай дүн гарч байна.



Маш богино хугацаанд үнэлгээг хийж батлуулсан бол наад зах нь иргэдэд мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад үнэлгээний ажлын төсөв, үнэлгээ эрхлэгчийн хөрөнгө санхүү, байгууллагын чадавх хангалттай байх хэрэгтэй. Цаашлаад үнэлгээний тайлангийн төслийг боловсруулж дуусаад ИНХ-ын хэлэлцүүлэх хангалттай хугацаа шаардлагатай.



БОННУ-ний төсвийн хүрэлцээ

БОННУ хийх ажлын зардал хууль, журамд заасан оролцоог хангах шаардлагыг биелүүлэхэд хүрэлцээтэй байна уу гэдэг жижиг, дунд төслүүдийн хувьд маш эргэлзээтэй байна. Улаанбаатар хотын ойр орчмын жижиг төслүүдийн үнэлгээ харьцангуй бага төсвөөр хийгдэж байна. Үнэлгээний олон жижиг компаниуд өрсөлдөж байдаг учраас заримдаа дундаж үнээс маш багаар буюу 500 мянгаас 2 сая орчимд тохирч үнэлгээ хийх тохиолдол байдгийг зарим оролцогч дурдсан байна.




Судалгаанд оролцсон үнэлгээ эрхлэгчдийн баримжаа тооцооллоор төслийн байршил, оролцоог хангах ажлын цар хүрээнээс хамаарч үнэлгээний ажлын төсвийн 5-10 хувийг оролцоог хангахтай холбоотой ажилд зарцуулдаг байна. Гэвч үнэлгээ эрхлэгчид үнэлгээний ажлын төсвийг төсөл хэрэгжүүлэгчтэй тохиролцохдоо оролцоог хангахад шаардлагатай зардлыг тусад нь тооцож оруулах боломж бага байдаг учраас аль болох бага зардлаар, шуурхай байдлаар санал авах, хэлэлцүүлэгт орох сэдэл болдог байна.


ИНХ-ын хэлэлцүүлгийн зохион байгуулалт

ИНХ-ын үнэлгээний хэлэлцүүлгийг одоогийн жишгээр ээлжит хурлаар хийх үү, ээлжит бус хурал зарлаж хийх үү, үнэлгээний урьдчилсан мэдээллийг хэн, ямар хэлбэрээр, хэзээ иргэдэд хүргэх вэ, орон нутгийн удирдлага, төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг хариуцлага ямар байх гэдэг асуултуудыг хууль, журамд тодорхой тусгайгүйн улмаас иргэдийн оролцоог хангахад бэрхшээл тулгарч байна. Нөгөөтээгүүр, хууль, журмаар БОАЖЯ-ын мэргэжлийн шинжээч, Мэргэжлийн зөвлөл хэлэлцүүлгийг зохион байгуулсан үйл явцад хяналт тавих буюу

Орон нутгийн удирдлага БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах журмыг мэддэг үү?



ИНХ-ын хуралдааны тэмдэглэлийн хуудасны тоо



дэлгэрэнгүй

тайлантай танилцах шаардлага байдаггүй учраас үнэлгээ эрхлэгч, төсөл хэрэгжүүлэгчид зөвхөн бичиг баримтын бүрдүүлэлт, дэмжсэн тогтоол авахад анхаарч байна.

Мэдээллийн ил тод байдал, хүртээмж

БОННУ-ний бүхий л үе шатны холбогдох мэдээллийг цаг тухай бүрд иргэдэд ил тод, хүртээмжтэй хэлбэр, арга, агуулгаар хүргэх хэрэгцээ маш их байна. БОННУ-ний мэдээллийн санд архив хэлбэрээр орж буй олон төрлийн мэдээллүүд үнэлгээг хийгдэж эхлэх үеэс иргэдэд хүрдэггүй нь олон нийтийн оролцоог хангахад маш их бэрхшээл учруулж байна. Зөвхөн иргэд биш орон нутгийн

удирдлага, төсөл хэрэгжүүлэгчид үнэлгээний суурь болон явцын мэдээллүүдтэй тухай бүрд нь танилцах боломжгүй байна. Батлагдсан БОННУ-ний тайлан бүхлээрээ улсын болон байгууллагын нууцад биш боловч тайлантай бүрэн эхээр нь танилцах боломж хязгаарлагдмал байна.

БОНБУ-ний талаарх мэдээлэл, ойлголтын зөрүү

Төсөл хэрэгжүүлэгчид, ялангуяа уул уурхайн бус чиглэлийнх, мөн сум, багийн удирдлагын үнэлгээний хууль, журмын талаарх ойлголт маш бага байна.

БОНБУ-ний талаарх мэдээлэл, сургалтын үйл ажиллагааг оролцогч талууд, ялангуяа төсөл хэрэгжүүлэгчид, сум, багийн удирдлагад зориулж зохион байгуулах, БОНБУ-г ямар зорилгоор хийдэг, яагаад иргэдээс санал авдаг, ямар ач холбогдолтой талаар иргэд, олон нийтэд зөв ойлгуулах мэдээлэл, сурталчилгааны хийх шаардлагатай байна.

Шийдлийн хувилбарууд

БОНБУ-ний хэрэгжилтийн талаарх өмнөх судалгаа, олон улсын туршлага, зарим шинжээчидтэй хийсэн ярилцлагад үндэслэн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах байдлыг сайжруулахад авч хэрэгжүүлж болох санал буюу шийдлүүдийн хувилбаруудыг оролцогч талын судалгаанд оролцогчдод танилцуулж, дэмжих эсэх болон яагаад гэдэг шалтгааныг асуусан. Санал болгосон 9 шийдлийн талаарх үнэлгээ эрхлэгчид /30 оролцогч/, уул уурхайн компаниуд /30 оролцогч/, орон нутгийн удирдлагын /30 оролцогч/ байр суурийг харьцуулсныг танилцуулж байна.

Үүнээс үнэлгээний явцад мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийсэн тайлан, нотлох баримтыг БОНБУ-ний тайланд хавсаргах /Санал 3/, төслийн ангиллаас хамаарсан оролцооны талаарх ялгаатай шаардлага бүхий аргачлал боловсруулах /Санал 4/, яамнаас иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын удирдамж, ажлын хуудас, маягтуудыг боловсруулж батлах /Санал 5/, үнэлгээний тайланг хүргүүлснээс хойш баг, хорооны хурлыг хуралдуулан тайланг тодорхой хугацааны дотор хэлэлцэхийг баг, хорооны удирдлага хариуцах /Санал 6/ саналын талаар оролцогч талуудын байр суурь харьцангуй эерэг, бусад саналуудын хувьд эерэг, сөрөг үр дагавар, бусад хууль, бодит амьдралд нийцэлтэй эсэхийг сайтар нягтлах хэрэгтэй гэж дүгнэж байна.

Хүснэгт 2. Шийдлийн хувилбаруудын талаарх оролцогч талуудын байр суурь

Үнэлгээ эрхлэгчид			Төсөл хэрэгжүүлэгчид			Орон нутгийн удирдлага			
Саналууд	Дэмжинэ	Дэмжихгүй	Мэдэхгүй	Дэмжинэ	Дэмжихгүй	Мэдэхгүй	Дэмжинэ	Дэмжихгүй	Мэдэхгүй
1	17	13	0	17	11	1	29	1	0
2	18	11	1	21	6	2	25	0	5
3	21	9		25	3	1	28	1	1
4	29	1		21	7	1	24	2	4
5	19	9	2	23	6	0	24	3	3
6	23	6	1	16	13	0	25	2	3
7	21	8	1	19	9	1	16	14	0
8	20	7	3	12	16	1	24	1	5
9	18	9	3	12	16	1	12	18	0

Саналууд

1. БОАЖЯ, орон нутгийн байгууллага Ерөнхий үнэлгээ хийх тухай эсвэл хийсэн талаар нийтийн зар мэдээ хүргэх, санал хүлээн авах
2. Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд оролцоог хангах ажлын шаардлагуудыг тодорхой тусгах
3. Үнэлгээний явцад мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийсэн тайлан, нотлох баримтыг БОНБУ-ний тайланд хавсаргах
4. Төслийн ангиллаас хамаарсан оролцооны талаарх ялгаатай шаардлага бүхий аргачлал боловсруулах
5. Яамнаас иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын удирдамж, ажлын хуудас, маягтуудыг боловсруулж батлах

6. БОНБУ-ний тайланг хүргүүлснээс хойш баг, хорооны хурлыг хуралдуулан тайланг тодорхой хугацааны дотор хэлэлцэхийг баг, хорооны удирдлага хариуцах
7. Олон нийт, иргэдээс санал авах ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх
8. БОНБУ-ний талаар баг, сумаас Олон нийтийн сонсгол зохион байгуулах
9. Зөвхөн баг, хорооны ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар /шинэ хуулиар Зөвлөл/ үнэлгээний тайланг хэлэлцдэг байх

Эдгээр шийдлээс гадна судалгаанд оролцогч талууд маш олон саналуудыг дэвшүүлсэн бөгөөд тодорхой эрэмбэ дараалалгүйгээр бүлэг сэдвүүдээр ангилан танилцуулж байна.

Саналуудын ангилал	Судалгаанд оролцогчдын санал
Төслийн ангиллаас хамаарсан оролцооны ялгаатай шаардлага тавих	- Төслүүдийн төрөл, нөлөөлөл, ангилал, хамрах хүрээнээс хамаараад иргэдийн оролцоог хангах асуудлыг ялгаатай тусгаж өгөх - Уул уурхай болон хүнд үйлдвэрлэлийн төсөл дээр зайлшгүй ИНХ-аа хэлэлцүүлээд жижиг төслүүд дээр ИНХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх, иргэдийн саналыг авсан тайлангаа олон нийтэд ил тод мэдээлэх, тайланд хавсаргах, мэргэжлийн зөвлөлөөр сайн хэлэлцээд зөвлөмж өгөх - Орон нутгийн Байгаль орчны газарт үнэлгээний ангилалд үндэслэн БОННУ-ний тайланд дүгнэлт гаргах эрх мэдлийг шилжүүлэх замаар яамны ачааллыг бууруулж, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх - Жижиг төслүүдийн үнэлгээний тайлан нь маш цомхон, ойлгомжтой, тодорхой байх
Төлөв байдлын үнэлгээг хийх үед буюу ерөнхий үнэлгээний дүгнэлт гарахаас өмнө санал авах	- Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах шатанд буюу байгаль орчны үнэлгээний суурь төлөв байдлын үнэлгээ хийх үед иргэдэд мэдээлэл өгч, санал авах - Төлөв байдлын үнэлгээний үе шатанд багахан хэмжээний танилцуулга хурал зохион байгуулж, ийм байгууллага, энэ газар ийм үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулах гэж байна гэсэн мэдээлэл өгөөд тухайн үйл ажиллагааг сонирхож байгаа иргэд санал хүсэлтээ хүргүүлж болдог байх
Нарийвчилсан үнэлгээ хийж эхлэх болон явцад иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийх шаардлагыг хэрэгжүүлэх	- Хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр үнэлгээ хийх цар хүрээ, төлөвлөгөөгөө гаргах - Ерөнхий үнэлгээний дүгнэлт гараад нарийвчилсан үнэлгээг боловсруулж байх явцад иргэдийн саналыг аваад тайландаа тусгаад, хэрхэн тусгаснаа дараа нь хурал дээр танилцуулдаг байх - Журмын тодорхой хэсэг, тухайлбал иргэдээс санал авахаас өмнө тэдэнд ямар мэдээллийг, ямар хэлбэрээр, ямар цаг хугацаанд, хэн хүргэх вэ тухай, санал авах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэлбэр, иргэд саналаа чөлөөтэй хэлэх боломжийн баталгаа зэргийг амьдралд нийцсэн, маш тодорхой болгох - Ирсэн саналуудыг яаж тусгах, харгалзаж үзсэн бол яах, үзээгүй бол яах вэ гэдэг зохицуулалт нь байх - Орон нутгийн иргэдтэй хамтарч үнэлгээгээ хийх, ингэхдээ үнэлгээний ажилд багийн иргэдээс оруулж, мэдээллээр хангах, хамтран ажиллах - Нөлөөлөлд өртөх магадлалтай иргэдийн судалгааг гаргаж нарийвчилсан үнэлгээний явцад тэдний дунд санал асуулга, хэлэлцүүлэг, ганцаарчилсан уулзалт зохион байгуулж, тайланг хавсаргадаг болох хэрэгтэй.
Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангах	- Үнэлгээтэй холбоотой мэдээллийг цогц байдлаар нэг эх үүсвэрээс хялбар байдлаар иргэдэд түгээдэг байх - Орон нутгийн удирдлага төслийн эхний шатнаас иргэдэд мэдээлэл хүргэдэг байх, ингэхдээ зарлалын самбар, Фейсбүүк, бусад сувгаар мэдээллийг хүргэж байх - БОАЖЯ-аас, холбогдох төрийн байгууллагаас иргэдэд орон нутагт нь хийгдэж байгаа үнэлгээний талаар мэдээлэл өгдөг байх, үүнд

	байгаль орчны мэдээллийн санг үр дүнтэй, шуурхай ашигладаг хэлбэрт шилжүүлж сурталчлах • Багийн удирдлагын иргэдэд мэдээллийн хүргэх чиг үүргийг тодорхой болгох • Мэдээллийн хураангуйг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр буюу зурагт хуудас, мэдээллийн хуудас, видео контент байдлаар бэлтгэж хүргэх • Иргэдийн мэдээлэл авдаг гол сувгуудаар буюу телевиз, сонин, сошиалаар мэдээлэл хүргэх
ИНХ-ын тов, ирцтэй холбоотой үүсдэг чирэгдлийг арилгах	• ИНХ, ИТХ-ын товыг улирал тус бүрээр тодорхой тогтоож өгөх • Баг, хорооны үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулах • ИНХ-ын ээлжит бус, нэмэлт, хэсэгчилсэн хуралдаан хийх • Хурлын тов, зохион байгуулалт, ирц бүрдүүлэлтийг нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хуульд оруулж өгөх, үүнд хурлыг зохион байгуулах үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар хариуцлагын механизм байх ёстойг тусгах • Бүх үйл ажиллагааг цахим болгох, тухайн аймаг, сум, багийн удирдлага, ажилтнууд хурлын мэдээллээ цахимаар цаг тухай бүрд нь мэдээлдэг, хурлын цагаа мэдэгддэг харилцаа холбоотой байх
ИНХ-ын хэлэлцүүлгийн оролцоо, үр дүнг сайжруулах	• Иргэдийн хэлэлцүүлгийг уламжлалт аргаар биш иргэдийн оролцоог нэмэгдүүлэх идэвхжүүлэх аргууд ашиглах • Иргэдийн саналыг бичгээр авах, ингэхдээ хувь хүний нууцыг хамгаалах • Иргэдийн санал хүсэлтийг тусгасан, тусгаагүй, тусгах боломжгүй тухайд эргэж мэдэгддэг байх буюу тайланд тусгах түүнийхээ дараа тайлангаа ИНХ-аар оруулж хэлэлцүүлэх • Үнэлгээг хийж эхлэх үеэс төлөвлөгөөгөө багт танилцуулж хэзээ хурлаар хэлэлцүүлэхээ тохирдог байх • Ээлжит бус хурал зохион байгуулж үнэлгээг дангаар нь хэлэлцэх • Хурал болохоос өмнө иргэдэд зориулсан танилцуулга зохион байгуулах • Үнэлгээний тайлангийн хураангуй, танилцуулгыг иргэдэд маш ойлгомжтой болгож боловсруулах • БОАЖЯ, аймгийн Байгаль орчны газраас холбогдох мэргэжилтэн оролцох, хяналт тавих • Иргэдэд хурлын зар мэдээг сайн хүргэхдээ бичгээр санал өгөх хуудсыг хүргүүлж хуралд ирэхдээ саналаа өгч болохуйцаар зохион байгуулах • Үнэлгээний тайланг хэлэлцэх зар мэдээ, холбогдох бүх мэдээллийг өгснөөс хойш 5-7 хоногийн дараа хурлаар хэлэлцүүлдэг байхаар уялдуулах • Хурлаар хэлэлцүүлэх тайлангийн төсөлд хэчнээн хүнээс, ямар санал авсан, тэдгээрийн дагуу ямар арга хэмжээг тусгасан гэдгийг тодорхой тусгасан байх • Үнэлгээний тайланг хэлэлцэхэд хүмүүс цуглуулахын тулд тодорхой хэмжээнд иргэдийн сонирхол татсан арга хэрэглэх, жишээ нь урамшуулал, сугалаа
Оролцооны талаарх талуудын ойлголтын зөрүүг арилгах	• Багийн ИНХ-аас гарсан шийдвэрийг яам талаасаа авч үзэхдээ дэмжих/дэмжихгүй гэсэн саналыг нь голчлох биш иргэдээс ирсэн саналуудыг нарийвчилсан үнэлгээнд хэрхэн тусгасан байна вэ гэдгийг нь харгалзаж үзэх • БОНБУ-ний зорилго, түүнд иргэдийн оролцоо ямар үүрэгтэй талаар талууд нэгдмэл ойлголттой болох, үүнд үнэлгээний компаниудыг төсөл хэрэгжүүлэгчийн талд үйлчилж, зөвшөөрлийг авч өгдөг гэсэн ташаа ойлголтыг өөрчлөх • Иргэдэд БОНБУ хийхийн ач холбогдол, түүнд санал авах явц ямар үүрэгтэй болохыг сайтар сурталчлан таниулах
Үнэлгээний талаарх иргэдийн	• Орон нутгийн иргэд, орон нутгийн удирдлагад БОНБУ-ний талаарх суурь ойлголт өгөх, өөрсдийн оролцоо, эрх үүргээ бүрэн

мэдлэг, ойлголтыг сайжруулах	хэрэгжүүлэх арга замуудын талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх
Үнэлгээний тайлангийн ил тод байдал, иргэдэд хүртээмжтэй байдлыг сайжруулах	• Үнэлгээний тайлангийн ил тод байдал, иргэд танилцах хэвлэмэл болон цахим хэлбэрээр чөлөөтэй танилцах боломжийн талаар хууль, журамд маш тодорхой тусгаж өгөх • ЗДТГ-ын байран дээрээ ямар нэг албан тушаалтны зөвшөөрөлгүй, шалгуургүйгээр очиж үзэж болдог байх • Үнэлгээний тайланг бүрэн эхээр нь, ерөнхий мэдээлэл авах гэж байгаа хүн хураангуй танилцуулга байдлаар нь орон нутгаасаа үзэх боломжтой байх • Хэвлэмэл байдлаар байхаасаа гадна тухайн орон нутгийн иргэдийн хамгийн их үздэг цахим хуудас, телевизийн сувгаар байршуулах
Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах	• БОННУ-ний дагуу боловсруулсан менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хариуцлага, хяналтын механизмыг сайжруулах • Жил бүрийн менежментийн төлөвлөгөө батлах, шалгах эрх бүхий субъектүүд нь тухайн төсөл иргэдийн оролцоог хангасан эсэхийг шалгаж, хангаагүй бол асуудал тавьдаг байх
Үнэлгээний санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулах	• Үнэлгээний ажлын зардалд олон нийтийн оролцоог хангахтай холбоотой зардлыг тусгах, үүний тулд үнэлгээний ажлыг хэт хямд үнээр, чанаргүй хийхээс сэргийлсэн жишиг тариф тогтоох, зардлын санхүүжилтийн хяналт, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
Үнэлгээний ажлын чанарыг сайжруулах	• Үнэлгээний компаниудын чадавх, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагыг чангаруулах, үнэлгээ хийх хугацааг аль болох хангалттай тавьж өгөх, яамнаас үнэлгээний тайлангийн агуулгад илүү гүнзгий дүн шинжилгээ хийдэг болох • Үнэлгээний компаниудын чадавхыг сайжруулах, улмаар олон нийтийн эерэг ойлголтыг бий болгох. Үүний тулд үнэлгээний компанид тавигдах шаардлагуудыг өндөрсгөх, үйл ажиллагааны ил тод байдал, тайлагналыг сайжруулах, тодорхой чиглэл, салбарын мэргэжилтнүүдийн оролцоог хангах • Холбогдох чиглэлийн ТББ-уудын оролцоо, хяналтыг бий болгох. Үүнд БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ТББ-уудын төлөөллийг оруулах, иргэдийн санал авах, хэлэлцүүлэг хийхэд ТББ, бусад холбогдох байгууллагуудыг оролцоог хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх, иргэдэд мэдээлэл хүргэх, сургалт, сурталчилгаа хийхэд хамтран ажиллах
Төслийн мөчлөгийн бусад үе шатуудын хариуцлагыг сайжруулах	• Уул уурхайн төслийн үнэлгээнд хайгуулын шатанд иргэдэд мэдээлэл танилцуулга хийж, санал авах зохицуулалт оруулах замаар БОНБУ хийх үед тулгардаг үл ойлголцлоос сэргийлэх
ИНХ-аар хэлэлцүүлдэг одоогийн шаардлагыг өөрчлөх	• Сумын ИТХ, багийн хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх • Иргэдийн санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, түүний тайлангаа багийн удирдлагад танилцуулах • Багийн иргэд, ялангуяа нөлөөллийн бүсийн иргэдийн санал асуулга судалгаа хийх • Иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, түүнд яам, холбогдох газраас хүмүүс оролцож, хяналт тавих

Олон улсын туршлага

Монгол улсын гео-эдийн засгийн онцлог, бүс нутгийн хамтын ажиллагааны чиг хандлагыг харгалзан үзэж БНХАУ, ОХУ, БНСУ, Казакстан улс, хөгжиж буй ижил төстэй

улсууд болох Перу, Ботсвана, уул уурхай, ХАА, аялал жуулчлалын салбарт түшиглэн өндөр хөгжсөн Австралийн Квинсланд мужийн туршлагыг судлан үзсэн.²

Энэхүү судалгаанд авч үзсэн улсуудын туршлагаас үзэхэд Монгол улсын БОНБУ-ний тогтолцоонд олон нийтийн оролцоог хангах зохицуулалт маш ерөнхий байна. Төслийн үнэлгээний талаар зөв ойлголттой болоход шаардлагатай мэдээллийг иргэд эхлээд авах ёстой, түүний дараа тухайн төслийн үнэлгээний талаар асуулт, санал хэлэх боломжтой болно гэдэг суурь зарчим Монгол улсын БОНБУ-ний хуульд тодорхой байдлаар суугаагүй байна /БНХАУ, ОХУ-ын жишээг хавсралтаас үзнэ үү/. Бусад улсуудын хууль, журмаар маш тодорхой заасан олон нийтэд зар мэдээ хүргэх хэлбэр, хугацаа, хариуцах этгээдийн талаар Монгол улсын хууль, журамд огт хөндөөгүй байна.

Хүснэгт 1. Тайлангийн төслийн хэлэлцүүлэг

	Монгол	БНХАУ	ОХУ	БНСУ	Казакстан	Ботсвана	Перу	Австрали /Квинсланд/
Албан ёсны хэлэлцүүлгийг бие даасан сонгол, хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулдаг уу?	Үгүй /ИНХ-аар заавал/	Тийм /Шаардлагатай бол/	Тийм /Заавал/	Тийм /Шаардлагатай бол/	Тийм /Заавал/	Тийм /Шаардлагатай бол/	Тийм /Заавал/	Тийм /Шаардлагатай бол/
Сонгол, хэлэлцүүлгийг зохион байгуулах тухай зар мэдээлэл хүргэх ёстой юу?	Үгүй	Тийм /10-аас цөөнгүй хоногийн өмнө/ /Цахим, сонин, самбар/	Тийм /30-аас цөөнгүй хоногийн өмнө/ /Цахим, сонин/		Тийм /20-иос цөөнгүй хоногийн өмнө/ /Цахим, сонин, радио, ТВ/	Тийм /30-аас цөөнгүй хоногийн өмнө/ /Сонин/	Тийм /30-аас цөөнгүй хоногийн өмнө/ /Гол сувгаар/	Тийм /30-аас цөөнгүй хоногийн өмнө/ /Сонин, цахим/
Сонгол, хэлэлцүүлэг болохоос өмнө тайлангийн төслийн мэдээллийг иргэдэд нээлттэй байршуулдаг уу?	Үгүй	Тийм /10-аас цөөнгүй хоног/ /Цахим/	Тийм /30-аас цөөнгүй хоног/ /Цахим, цаасаар/	Тийм /20-60 хоног/ /Цахим/	Тийм /30-аас цөөнгүй хоног/ /Цахим, цаасаар/	Тийм /30-аас цөөнгүй хоног/	Тийм /30-аас цөөнгүй хоног/	Тийм /30-аас цөөнгүй хоног/ /Цахим, цаасаар/

Үнэлгээний тайлангийн төслийг ИНХ буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаар хэлэлцүүлдэг зохицуулалт зөвхөн Монгол улсад байна. Бусад улсуудын хувьд төсөл хэрэгжүүлэгч орон нутгийн захиргаатай хамтран хэлэлцүүлэг, сонгол зохион байгуулж байна. Энэ нь хэлэлцүүлгийг хурдан шуурхай зохион байгуулах, олон нийтэд урьдчилж зар мэдээ хүргүүлэх, иргэдэд мэдээлэлтэй танилцаж, уншиж судлах хугацаа олгох давуу талуудыг бий болгож байна. Оролцогчдын ирц чухал боловч түүнээс илүүтэй зар мэдээ, үнэлгээний мэдээллийг хүртээмжтэй, нээлттэй байлгахад анхаарч, улмаар хэлэлцүүлгийн тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэх замаар хяналтыг хангахыг зорьж байна.

Нарийвчилсан үнэлгээний эхлэл үеэс буюу Ажлын даалгаврыг боловсруулах шатнаас орон нутгийн иргэдээс санал авах, зөвлөлдөх үйл явцыг хэрэгжүүлж байгаа бусад улсын туршлага нь Монгол улсын хууль, журамд байдаг боловч хэрэгжилтийн хангах нарийвчилсан зохицуулалт үгүйлэгдэж байна.

Монгол улсад БОННУ хийх шаардлагатай төслийн хүрээ маш өргөн, дотор нь ялгасан ангилал байхгүй, түүнээс хамаарч оролцооны шаардлага бүх төслүүдийн үнэлгээнд ижилхэн байдаг нь олон улсын туршлагаас ажиглагдаж байна. БОННУ хийх төслийн хүрээг хумьж, сөрөг нөлөөлөл ихтэй, нийгэм, эдийн засгийн, стратегийн чухал ач

² АМЕП-2. БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай олон улсын туршлага. 2021

холбогдолтой төслүүдийн үнэлгээний чанар, оролцоог сайжруулах, бусад төслүүдийн хувьд хялбаршуулсан үнэлгээ хийх, байгаль орчны зөвшөөрлийн журмаар зохицуулах бодлого харьцуулсан улсуудад нийтлэг байна. Жишээ БНХАУ-д 2018 оны байдлаар БОНБУ хийсэн төслүүдийн 80 хувь нь БОНБУ-ний Маягт боловсруулж, 12 хувь нь Бүртгэлийн маягт бөглөж, зөвхөн 8 хувь нь БОННУ-ний тайлан боловсруулсан байна.

Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах асуудлыг зөвхөн төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ эрхлэгч хариуцдаг тогтолцооноос төрийн байгууллага идэвхтэй дэмжих, хяналт тавих байдлаар хамтран ажиллах тогтолцоо руу шилжихэд төслийн зөв ангиллыг тогтоох, орон нутагт эрх мэдэл хуваарилах байдлаар төрийн байгууллагын ачааллыг зөв зохицуулах шаардлага тулгарч байна.

Хүснэгт 2. Зарим улсууд дахь Төслийн БОНБУ-ний ангилал

Улсууд	Төслийн БОНБУ-ний ангилал
БНХАУ	БОННУ, БОНБУ-ний Маягт, Бүртгэлийн маягт
БНСУ	БОННУ, Бичил БОНБУ
Казакстан	БОННУ, Хялбаршуулсан журмаар хийх үнэлгээ
Перу	БОННУ, Хагас нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн мэдүүлэг

Бодлогын зөвлөмжүүд

Монгол улсын БОНБУ-ний тогтолцоонд олон нийтийн оролцооны зохицуулалтыг боловсронгуй болгоход БОНБУ-ний тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудыг өөрчлөх, БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах журмыг бүхэлд нь шинэчлэх хэрэгцээ үүсэж байна. Ингэхдээ тогтолцооны төвшинд болон нэгж асуудлаар дараах шинэчлэл, өөрчлөлтийг хийх шаардлагатай байна. Үүнд:

БОНБУ-ний тогтолцооны төвшинд:

- Хууль, журмаар олон нийтийг мэдээллээр хангах, санал хүлээн авах, саналыг боловсруулах, эргэн тайлагнах талуудын үүргийг тодорхой, ойлгомжтой, хянан магадлах боломжтой болгох
- Монгол улсын Үндсэн хуульд заасан “иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрх”-ийг хангахын тулд үнэлгээний тайлангийн төсөл болон батлагдсан хувилбарыг бүрэн эхээр нь хэвлэмэл болон цахим хувилбараар ил тод болгох
- Ерөнхий үнэлгээ болон БОННУ хийх шаардлагатай төслүүдийн шалгуур үзүүлэлтийг нарийвчлах
- Зарим төсөлд тохирсон БОННУ-ээс өөр хялбаршуулсан үнэлгээ /жишээ нь хагас нарийвчилсан үнэлгээ, нөлөөллийн үнэлгээний маягт/, зөвшөөрлийн хэлбэрийг нэвтрүүлэх, түүнээс хамаарч Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн хүрээ, хүчинтэй хугацаа, олон нийтийн оролцооны шаардлагыг ялгаатай зохицуулах
- Үнэлгээний ангиллаас хамаарч үнэлгээний тайланг баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлэх зохицуулалтыг 2022 оны 1 сараас хэрэгжих ЗЗНДНТХ-д нийцүүлэн ИНХ-ын оновчтой болгох, үүнд төслийн ангиллаас хамаарч ИНХ-аар хэлэлцүүлэх, БОАЖЯ-ны итгэмжлэлээр баг, хороо сонсох ажиллагаа зохион байгуулах, эсвэл багийн удирдлагын байгаль орчныг хамгаалахад хяналт тавих үндсэн үүргийн дагуу бие даасан, ил тод хэлэлцүүлэг зохион байгуулах хувилбартай байх

- Байгаль орчны мэдээллийн сангийн БОНБУ-ний мэдээлэл нь одоо хэрэгжиж буй үнэлгээний ажлуудыг дэмжих зорилготой цаг үеийн зар мэдээ, олон нийтээс санал авах баримт бичгийн төслийг агуулсан real-time хувилбартай байх
- Үнэлгээ эрхлэгч компаниудыг хүний нөөц, хөрөнгө санхүү, чанарын хяналтын тогтолцоо, туршлагыг харгалзан ангилах, үнэлгээний ангиллаас хамаарч ялгаатай эрх олгох замаар үнэлгээний тайлангийн чанарыг сайжруулах, компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах, ялангуяа иргэдээс санал авах үйл ажиллагааны зорилго, ач холбогдлыг иргэдтэй зөвлөлдөх гэдэг агуулгаар тайлбарлан сурталчлах
- Хууль, журам зөрчсөн, ёс суртахууны алдаа гаргасан үнэлгээ эрхлэгчдэд хүлээлгэх шийтгэл болон ёс зүйн хариуцлагыг тодорхой болгох

Олон нийтийг мэдээллээр хангах

- Нийтийн зар мэдээ, мэдэгдлийн хэлбэр, хугацаа, агуулга, хариуцлагыг БОНБУ-ний хууль, журмаар нарийвчлан зохицуулах
- Олон нийтэд зар мэдээ, үнэлгээний талаарх мэдээлэл хүргэх үйл ажиллагааны тайлан, нотлох баримтыг үнэлгээний тайланд тусгах
- Олон нийттэй зөвлөлдөх уулзалт, төслийн тайлангийн хэлэлцүүлэг хийсэн үйл явц, үр дүнг олон нийтэд цахим болон бусад хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэх зохицуулалт хийх
- Нарийвчилсан үнэлгээний тайлан нь мэргэжлийн бус хүмүүс уншиж ойлгоход хялбар техникийн бус хураангуйтай байх
- Байгаль орчны мэдээллийн сангийн үнэлгээний талаарх мэдээлэл нь техникийн бус хэллэгтэй, энгийн ойлгомжтой, товч хувилбартай байх

Нарийвчилсан үнэлгээний явцын оролцоог хангах

- Ажлын даалгавар боловсруулах шатнаас иргэдээс санал авах үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, хариуцлагыг тодорхойлох
- Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын удирдамжийг олон нийтэд мэдээлэх, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, бичгээр санал авах
- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоосны дараа орон нутгийн иргэдэд танилцуулга хийж, санал авах
- Хэлэлцүүлэг зохион байгуулж санал авахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцоход шаардлагатай арга, хэлбэрийг сонгох, дэмжлэг үзүүлэх
- Явцын оролцоог хангахын тулд журамд заасан олон нийтийн саналын нэгдсэн дүнг товч тайлан хэлбэрээр ИНХ-аар тайланг хэлэлцүүлэхээс өмнө олон нийтэд цахимаар нээлттэй байршуулах зохицуулалт хийх

Үнэлгээний тайлангийн төслийн хэлэлцүүлгийг боловсронгуй болгох нь

- ИНХ-аар тайланг хэлэлцүүлэх зохицуулалт нь ИНХ-ын хуваарьт нийцсэн, иргэд, олон нийтэд тайлангийн мэдээлэлтэй танилцах зохих хугацаа олгосон, хэлэлцүүлгийн дэг нь тодорхой, тэмдэглэл, тогтоолыг хууль, журмын үзэл баримтлалд нийцүүлэн журамлаж, жишиг загвар, маягтаар хангасан байх
- Хэлэлцүүлгийг зохион байгуулахаас 10-30 өдрийн өмнөөс олон нийтэд зарлах хэлбэр, агуулга, хариуцлагыг хууль, журамд тодорхой тусгах

- Тайлангийн төслийг бүрэн эхээр цахимаар болон хэвлэмэл хэлбэрээр уншиж танилцах 10-30 өдрийн хугацаа олгох
- Тайлангийн төслийн талаар асуулт, саналаа цахим болон бичгээр БОАЖЯ болон орон нутгийн эрх бүхий байгууллагад илгээх хэлбэр, хаяг тодорхой байх
- Хэлэлцүүлэгт иргэд, оролцогч талууд сайн дураар оролцох, санал бодлоо бичгээр илэрхийлэх боломжоор хангах
- Хэлэлцүүлгийг наад зах нь нэг удаа буюу хэд хэдэн удаа зохион байгуулж, иргэд, оролцогч талуудын оролцоог аль болох бүрэн хангах зохицуулалт хийх
- Хэлэлцүүлгийн зохион байгуулалт, дэг, тайланг журмаар нарийвчлан зохицуулах, холбогдох аргачлал, загвар, маягтуудыг батлах
- Хэлэлцүүлгийн тайланг олон нийтэд тухай бүрд нь буюу хэлэлцүүлэг дууссанаас хойш 5 өдрийн дотор ил тод мэдээлдэг байх
- Хэлэлцүүлгийн үйл явц, үр дүнг, холбогдох баримтыг үнэлгээний тайлангийн Олон нийтийн оролцооны эсвэл олон нийттэй зөвлөлдөх үйл ажиллагааны хэсэгт тусгах
- Хэлэлцүүлэг зохион байгуулагдахад талуудын хооронд маргаан гарсан, хэлэлцүүлэг олон удаа хойшилсон зэрэг тохиолдолд хамтарсан ажлын хэсэг ажиллаж асуудал шийдвэрлэх арга замыг хууль, журамд тусгах
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн орон нутгийн удирдлага, БОАЖЯ-ны үүргийг тодорхой тусгах
- Захиргааны ерөнхий хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх явцын хэлэлцүүлэг болон ИНХ-аар тайланг хэлэлцүүлэх үйл ажиллагаатай холбоотой оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх талаар иргэн хүсэлт гаргасан, эсхүл захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл БОАЖЯ-наас шинжээч томилон дүгнэлт гаргуулах зохицуулалт оруулах

Үнэлгээний шийдвэр, тайлангийн ил тод байдлыг хангах

- “Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарснаас хойш 5-7 хоногийн дотор дүгнэлтийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулах, 7-14 хоногийн дотор байгаль орчны мэдээллийн санд оруулах
- Батлагдсан үнэлгээний тайлангийн олон нийтэд зориулсан /бизнесийн нууцад хамаарах хэсгийг дарсан буюу хассан/ хувилбарыг батлагдсанаас хойш 6-12 сарын хугацаанд цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй байршуулах
- Батлагдсан үнэлгээний тайлангийн олон нийтэд зориулсан /бизнесийн нууцад хамаарах хэсгийг дарсан буюу хассан/ хувилбарыг хэвлэмэл хэлбэрээр орон нутгийн нийтийн номын санд /жишээ нь сумын/ хадгалж, иргэд, сонирхогч талууд чөлөөтэй уншиж танилцах боломжоор хангах

Хавсралт 1: Холбогдох эрх зүйн баримт бичиг

- Монгол улсын үндсэн хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам
- Нийтийн сонсгол зохион байгуулах журам
- Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах үнэлгээ хийх аргачлал
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал
- Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам

Хавсралт 2: Хөрш зэргэлдээ улсуудын БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах зохицуулалтын жишээ

- БНХАУ

БОННУ хийх шийдвэр гарсны дараа
Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн цахим хуудас эсвэл орон нутгийн удирдлагын цахим хуудаснаа дараах мэдээллийг нийтэлнэ. Үүнд: 1. Төслийн суурь мэдээлэл: төслийн нэр, байршил, гол үйл ажиллагаа 2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, холбоо барих хаяг 3. Үнэлгээ эрхлэгчийн нэр 4. Саналаа илэрхийлэх маягтыг хаанаас татаж авч болох тухай 5. Саналын хуудсаа хэрхэн илгээх тухай Санал авах хуудасны маягтыг яамнаас батална.
БОННУ-ний тайлангийн төсөл боловсруулж дууссаны дараа
Төсөл хэрэгжүүлэгч дараах мэдээллийг олон нийтэд мэдээлнэ: 1. Үнэлгээний тайлангийн төсөлтэй хаанаас танилцаж болох тухай 2. Саналаа хэнд хүргүүлэх тухай 3. Саналын хуудас татаж авах хаяг 4. Бичгээр саналаа хэрхэн гаргах тухай 5. Бичгээр саналаа хэзээ гаргах тухай Ажлын 10-аас цөөнгүй өдрийн хугацаанд олон нийт санал гаргах боломжтой байна. Хэрэв нөлөөллийн талаар олон тооны асуулт, сөрөг саналууд гарсан бол олон нийтийн хэлэлцүүлэг, сонсгол, хурал зэрэг илүү гүнзгий зөвлөлдөх арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч зохион байгуулах ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг зохион байгуулахаас 10-аас цөөнгүй өдрийн өмнө зарлан мэдээлж хэлэлцүүлэг, сонсголд оролцох сонирхлоо илэрхийлсэн хүмүүсийг бүртгэх, оролцуулах шаардлагатай хүмүүсийг урих ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг дууссанаас

хойш 5 өдөрт багтаан хурлын тэмдэглэлийг бэлтгэж олон нийтэд цахимаар ил тод болгох ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг зохион байгуулахдаа холбогдох орон нутгийн захиргааны байгууллагаас зөвлөмж, дэмжлэг авч болно.

Төсөл хэрэгжүүлэгч олон нийтийн гаргасан саналыг анхааралтай шинжлэн үзэж дараах агуулгын хүрээнд тайлан мэдээлэл бэлтгэнэ. Үүнд:

1. Олон нийтийн оролцоог хангах үйл явц, цар хүрээ, авсан арга хэмжээ
2. Саналуудын хэрхэн цуглуулж, дүн шинжилгээ хийсэн тухай
3. Олон нийтийн саналын дагуу авсан арга хэмжээ, хариу тайлбар

Төсөл хэрэгжүүлэгч нь БОННУ-ний тайлангийн төслийг төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлэхийн өмнө түүнийг бүрэн эхээр нь, олон нийтийн оролцооны тайлан мэдээллийн хамтаар өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна.

Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний тайлангийн төсөл, олон нийтийн оролцооны тайлан мэдээллийг хүлээн авсны дараа

Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний тайланг хүлээн авсны дараа дараах мэдээллийг өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна. Үүнд:

1. БОННУ-ний тайлан бүрэн эхээрээ
2. Олон нийтийн оролцооны тайлан мэдээлэл
3. Олон нийт саналаа хэрхэн гаргах тухай

Эрх бүхий байгууллага уг мэдээллийг ажлын 10-аас цөөнгүй өдрийн хугацаанд нээлттэй байлгана.

Эрх бүхий байгууллага БОННУ-ний тайланг хэлэлцээд дүгнэлт гаргахын өмнө

Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний эцсийн тайланг хүлээн авсны дараа дараах мэдээллийг өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна. Үүнд:

1. Төслийн нэр ба байршил
2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
3. Үнэлгээ эрхлэгчийн нэр
4. Төслийн хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа, байгаль орчны гол нөлөөлөл, хариу арга хэмжээ
5. Төсөл хэрэгжүүлэгчийн олон нийтийн оролцоог хангах талаар явуулсан үйл ажиллагаа
6. Санал, хүсэлт хэрхэн гаргах тухай

Ажлын 5-аас цөөнгүй өдрийн хугацаанд мэдээллийг ил тод байлгана. Энэ мэдээллийн зэрэгцээ олон нийт болон төсөл хэрэгжүүлэгчид хэрэв хүсэлт гаргавал олон нийтийн сонсгол зохион байгуулах боломжтой болохыг мэдэгдэнэ.

Эрх бүхий байгууллага нь олон нийтийн саналыг авах хуулийн шаардлагыг биелүүлсэн эсэхийг шалгаж, олон нийтийн саналыг нарийвчлан авч үзнэ. Хэрэв шаардлага хангахгүй бол төслийг буцаана.

Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний тайланг хэлэлцээд дүгнэлт гаргасны дараа

Дүгнэлтийг өөрийн цахим хуудаснаа байршуулна. Мөн энэ талаар захиргааны гомдол гаргах, авч хэлэлцэх талаарх мэдээллийг байршуулна.

• ОХУ

БОННУ хийх шийдвэр гарсны дараа

Төсөл хэрэгжүүлэгч нь БОННУ хийх Ажлын даалгаврын төслийг боловсруулна. Үүний дараа төсөл хэрэгжүүлэгч нь холбооны, мужийн, орон нутгийн хэмжээний сониноор дамжуулан Ажлын даалгаврын төслийн тухайд олон нийтээс санал авах тухай олон нийтэд зар мэдээ хүргэх ёстой. Үүнд дараах мэдээллийг багтаана.

- Төлөвлөсөн үйл ажиллагааны нэр, зорилго, байршил;
- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг;

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх хугацаа; - Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах үүрэг бүхий байгууллага; - Олон нийтийн хэлэлцүүлгийн хэлбэр (санал асуулга, сонсгол, анкет судалгаа гэх мэт), санал гаргах арга, хэлбэр - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх Ажлын даалгавартай танилцах арга, хугацаа, байршил; - Бусад мэдээлэл. Ажлын даалгаврын төслийг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор иргэд санал, хүсэлтээ илгээж болно. Олон нийтээс ирсэн саналыг харгалзан үзэж Ажлын даалгаврын эцсийн хувилбарыг боловсруулна.
БОННУ-ний тайлангийн төслийг илгээхийн өмнө Тайлангийн төслийн талаар олон нийтийн сонсгол зохион байгуулах ёстой. Төсөл хэрэгжүүлэгч орон нутгийн захиргаанд хүсэлт хүргүүлнэ. Орон нутгийн захиргаа сонсгол зохион байгуулах тогтоол гаргана. Нийтийн сонсгол зохион байгуулах огноо, байршлын тухай зар мэдээ сонсгол зохион байгуулагдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө албан ёсны эх сурвалжуудад /сонин/ нийтлэгдсэн байх ёстой. Төсөл хэрэгжүүлэгч үнэлгээний тайлангийн төслийн мэдээллийг олон нийтэд 30 доошгүй хоногийн турш нээлттэй байршуулах ёстой. Орон нутгийн захиргаа сонсголд оролцох хүсэлтэй иргэдийг бүртгэх /30 хоногийн турш/, олон нийтийн сонсгол зохион байгуулах, сонсголын тэмдэглэлийг бэлтгэх үүрэгтэй /5 хоногт багтаана/. Сонсгол зохион байгуулах зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна. Тэмдэглэлийг төсөл хэрэгжүүлэгч, орон нутгийн удирдлага, олон нийт гэсэн гурван талын төлөөлөл нягталж гарын үсэг зурдаг. Дараа нь түүнийг бусад баримт бичгийн хамт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хавсаргана. Сонсгол дээр ямар ч шийдвэр гаргахгүй бөгөөд төслийн талаар иргэдэд мэдээлэл өгөх, тэдний санал хүсэлтийг хүлээн авах явдал гэдгийг онцолдог. Хуулийн дагуу сонсгол дууссанаас хойш 30 хоногийн дотор иргэд бичгээр санал, хүсэлтээ илгээж болно.
Үнэлгээний тайланд тусгах асуудлууд Үнэлгээний журмын дагуу тайланд дараах мэдээлэл орсон байх ёстой. 12. Үнэлгээний тайланг бэлтгэх явцад олон нийтээс санал авах ажлын тайлан: 12.1. Олон нийтээс санал авах арга, цаг хугацаа, хэлбэрийг зэргийг зарлан мэдээлсэн арга 12.2. Санал авах үйл ажиллагаанд оролцсон иргэдийн овог, нэр, байгууллагын нэр (хэрэв байгууллага төлөөлж оролцсон бол), түүнчлэн эдгээр байгууллагын хаяг, утасны дугаар эсвэл хэлэлцүүлэгт оролцогчдын хаяг, утасны дугаар 12.3. Санал гаргасан иргэдийн хөндсөн асуудал, танилцуулга хийсэн бол түүний хувь, олон нийтийн сонсголын тэмдэглэл (хэрэв сонсгол зохион байгуулсан бол). 12.4. Хүлээн авсан санал, зөвлөмж, үүнд олон нийт, орон нутгийн засаг захиргаа, төсөл хэрэгжүүлэгчийн хооронд гарсан саналын зөрүүний талаарх дүн шинжилгээ 12.5. Олон нийтийн хэлэлцүүлэг, санал авах ажлын үр дүнд үндэслэсэн дүгнэлт. 12.6. Олон нийтийн саналын алийг нь харгалзан үзсэн, харгалзан үзээгүй бол ямар шалтгаанаар гэдгийг тайлбарласан тэмдэглэл 12.7. Үнэлгээний бүх үе шатанд оролцогч талуудад илгээсэн холбогдох мэдээлэл Түүнчлэн, тайланд түүний техникийн бус хураангуйг хавсаргах ёстой байна.

